



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/77


Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох,  
өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.5, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/89, А/243, А/275 дугаар захирамжуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн дагуу 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд тус жагсаалд оролцох 38 албан хаагчийг сонгож бэлтгэл, сургуулилтын явц, оролцоо, ирцэд анхаарч ажиллах, албан хаагчдыг нэгдсэн хувцас, хэрэглэлээр хангах ажлыг зохион байгуулах, зарлагдсан өдрүүдэд /04 дүгээр сарын 17, 22, 24-ний өглөө 04:30 цагт/ албан хаагчдыг унаа машинаар зөөвөрлөн, бэлэн байдлыг хангах, зохион байгуулалттай арга хэмжээнд оролцохоос зайлсхийсэн, татгалзсан, зөрчил гаргасан албан хаагчдад арга хэмжээ тооцох зэрэг ажлыг хийж гүйцэтгэхийг Захиргаа санхүүгийн хэлтсийн даргад даалгасугай.
2. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцоход шаардагдах зардлыг зохих сангаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.
3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажлын тусгай горимоор ажиллаж, бэлтгэл бэлэн байдлаа хангаж, холбоо барих боломжийг бүрдүүлэн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч даргад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

Тушаал-2019

115050000420